

БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2020 оны II улирлын тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт.....	3
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	4
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт.....	6
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	6
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	6
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт.....	7
Статистик үзүүлэлтүүд.....	7
Харилцагчид, зээлдэгчид.....	7
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид.....	8
Тархалт.....	9
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	10
Мөнгөн хөрөнгө.....	11
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	11
Факторингийн тооцооны авлага.....	11
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө.....	12
Зээл.....	12
Бусад хөрөнгө.....	13
Эргэлтийн бус хөрөнгө.....	14
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	15
Санхүүгийн эх үүсвэр.....	16
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг.....	16
Бусад эх үүсвэр.....	16
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	17
Төслийн зээлийн санхүүжилт.....	18
Бусад өр төлбөр.....	18
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	19
Бусад өмч, сангууд.....	19
Хуримтлагдсан ашиг/алдагдал.....	20
Хоёрдогч өглөг.....	20
Ашигт ажиллагаа.....	21
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	23
Дүгнэлт.....	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл.....	4
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан балансын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	4
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа.....	4
Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл.....	7
Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	8
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл.....	8
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	8
Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт.....	9
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт.....	9
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	10

Хүснэгт 11	Активын интервал /тэрбум төгрөгөөр/	10
Хүснэгт 12	Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 13	Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 14	Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 15	ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	12
Хүснэгт 16	Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 17	Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 18	Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 19	Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 21	Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	15
Хүснэгт 22	Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	16
Хүснэгт 23	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	16
Хүснэгт 24	Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 25	ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 26	Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 27	Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	18
Хүснэгт 28	Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 29	ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	19
Хүснэгт 30	Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	20
Хүснэгт 31	Хуримтлагдсан ашиг/алдагдал /мянган төгрөгөөр/	20
Хүснэгт 32	Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/	21
Хүснэгт 33	Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 34	ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/	23

Зургийн жагсаалт

Зураг 1	ББСБ-уудын тархалт	9
Зураг 2	Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	10
Зураг 3	Зээлийн багцын чанар	12
Зураг 4	Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	15
Зураг 5	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/	16
Зураг 6	Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/	17
Зураг 7	Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	18
Зураг 8	Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/	19
Зураг 9	Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	21

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2020 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 542 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 4 ББСБ буюу 0.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 77 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 31 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2016-II	2017-II	2018-II	2019-II	2020-II
Шинээр олгосон	53	20	10	5	12
Хүчингүй	4	5	5	6	8
Түдгэлзүүлсэн	0	17	15	6	25
Сэргээсэн	1	0	2	6	4
Нийт ББСБ	499	533	539	538	542
Үүнээс: ХОН	53	66	75	75	77
Үүнээс: ГХО	30	32	27	27	31
Салбар	124	126	190	235	278
Төлөөлөгч	4	4	4	7	9

2020 оны II улирлын байдлаар 12 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 8 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгож, 25 ББСБ-ын үйл ажиллагааг бүхэлд нь түдгэлзүүлж, 4 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2020 оны II улирлын байдлаар 11 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан балансын ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2019.II	2020.II	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,533.1	1,862.2	21.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.4%	5.4%	1.0%
Нийт өөрийн хөрөнгө	1,155.2	1,337.7	15.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	37.2%	43.8%	6.6%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	892.2	977.3	9.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	104.1%	134.1%	30.0%
Нийт зээл	1,024.5	1,307.3	27.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.2%	7.6%	1.2%
Нийт орлого	158.3	200.2	26.5%
Нийт зарлага	94.0	123.6	31.5%
Цэвэр ашиг	64.3	76.6	19.1%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өсөж, банкны салбарын 5.4%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

2020 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар буюу 329.1 тэрбум төгрөгөөр өсөж 1.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 64.0 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 25.9 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 26.5 хувиар буюу 41.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 31.5 хувиар буюу 29.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 19.1 хувиар буюу 12.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2019.II	2020.II	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		538	542	4	0.7%
1	Зээл	492	498	6	1.2%
Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		351	337	-14	-4.0%
2	Факторинг	24	34	10	41.7%
3	Төлбөрийн баталгаа гаргах	19	20	1	5.3%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	5	2	66.7%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	27	33	6	22.2%
6	Гадаад валютын арилжаа	154	159	5	3.2%
Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		44	44	-	-
7	Итгэлцэл	31	40	9	29.0%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	10	-	-
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	32	37	5	15.6%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 542 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 91.9% нь буюу

498 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 62.2% нь буюу 337 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 159 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 29.3 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 44 ББСБ нийт ББСБ-уудын 8.1% бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 41.7 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 22.2 хувиар өссөн байна. 2020 оны II улирлын тайлан мэдээний ирц 97.6% байна.

Тайлан мэдээг ирүүлбэл зохих 542 ББСБ-аас 529 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 13 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

- “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ыг боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [370 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4586 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [441 дүгээр ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4622 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [10 дугаар ТОГТООЛ](#)оор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн [122/58 тоот хамтарсан тушаалаар](#) өөрчлөлт оруулж, 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс

2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэр гаргаад байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-д 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн [148 дугаар тогтоол](#)оор өөрчлөлт оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2020 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 538 ББСБ-ын 81.4% буюу 438 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 408 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 498 ББСБ-ын 79.5% буюу 396 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 141 ББСБ, 5,348 удаагийн тохиолдлоор, 588.8 тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө,

Статистик үзүүлэлтүүд

2020 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 8,404 хувь нийлүүлэгчдийн 542 ББСБ, 278 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,372 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,766,913 харилцагч, 445,984 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	2,766,913	221,029	2,545,884	27,381	2,755,708	11,205	846,425	1,920,488	31,376
Үүнээс: Эмэгтэй	1,378,061	113,889	1,264,172	14,385	1,372,381	5,680	429,900	948,161	18,670
Эрэгтэй	1,385,385	103,977	1,281,408	12,644	1,379,906	5,479	416,204	969,181	12,511
Хуулийн этгээд	3,467	3,163	304	352	3,421	46	321	3,146	195
Итгэмжлэгчдийн тоо	3,741	3,448	293	-	3,349	392	264	3,477	264
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	816	213	603	-	801	15	573	243	14
Зээлдэгчдийн тоо	445,984	152,677	293,307	-	435,171	10,813	207,051	238,933	31,320
Хэвийн	388,703	136,593	252,110	-	379,809	8,894	183,163	205,540	28,119
Хугацаа хэтэрсэн	24,329	7,227	17,102	-	23,869	460	7,463	16,866	736
Чанаргүй:	32,952	8,857	24,095	-	31,493	1,459	16,425	16,527	2,465
-Хэвийн бус	6,772	3,032	3,740	-	6,323	449	1,390	5,382	978
-Эргэлзээтэй	13,958	2,240	11,718	-	13,328	630	8,337	5,621	359
-Муу	12,222	3,585	8,637	-	11,842	380	6,698	5,524	1,128
Зээлдэгчдийн насжилт	444,777	151,485	293,292	-	434,009	10,768	206,987	237,790	31,130
18-35 насны	246,234	64,271	181,963	-	242,482	3,752	127,486	118,748	13,216
36-45 насны	121,056	50,792	70,264	-	116,520	4,536	49,917	71,139	9,714
46-55 насны	58,041	26,705	31,336	-	56,218	1,823	22,610	35,431	5,976
55-аас дээш	19,446	9,717	9,729	-	18,789	657	6,974	12,472	2,224
Зээлдэгчдийн боловсрол	444,777	151,485	293,292	-	434,009	10,768	206,987	237,790	31,130
-Дээд	261,477	81,663	179,814	-	255,947	5,530	115,327	146,150	13,176
-Тусгай дунд	29,900	18,411	11,489	-	27,684	2,216	6,955	22,945	5,002
-Бүрэн дунд	132,266	44,177	88,089	-	130,290	1,976	72,074	60,192	11,837
-Дунд	16,218	6,033	10,185	-	15,448	770	9,452	6,766	1,065
-Бага	4,916	1,201	3,715	-	4,640	276	3,179	1,737	50

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өсөж 2,766,913, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өсөж 445,984-д хүрлээ.

Нийт харилцагчдын 92.0% буюу 2,545,884 нь, зээлдэгчдийн 65.8% буюу 293,307 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 8.0% буюу 221,029, зээлдэгчдийн 34.2% буюу 152,677 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч

байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 27,381 буюу нийт харилцагчдын 1.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2016-И	2017-И	2018-И	2019-И	2020-И	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	986	1049	4793	7618	8404	786	10.3%
Ажилчдын тоо	2048	2282	8602	2921	3372	451	15.4%
Харилцагчдын тоо	420,505	1,353,143	1,423,597	2,348,014	2,766,913	418,899	17.8%
Ээлдэгчдийн тоо	-	65,449	150,542	360,345	445,984	85,639	23.8%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	4.0%	3.5%	3.3%	3.4%	2.9%	-0.5 пункт	

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 7,352 буюу 87.5% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,052 буюу 12.5% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,097 буюу 13.1% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 183 буюу 2.2% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,404	2,063	6,342	68	8,221	183	7,352	1,052	1,097
Нийт ажилтнуудын тоо	3,372	3,019	383	136	3,169	203	258	3,114	375
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	1,965	1,757	224	82	1,828	137	152	1,813	198

Хөдөө орон нутгийн 77 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 85 үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
ТЗ-тэй ББСБ-ын тоо	542	532	11	44	465	77	4	538	31	511
ТЗ-тэй үйлчилгээний тоо	836	792	46	44	751	85	22	814	58	778
ТЗ-тэй үйл ажиллагааны тоо	9	9	8	1	9	5	9	9	8	9
1 Зээл	498	488	11	-	423	75	4	494	31	467
2 Факторингийн үйлчилгээ	34	29	6	-	34	-	2	32	2	32
3 Төлбөрийн баталгаа гаргах	20	20	-	-	20	-	1	19	5	15
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	3	-	5	-	1	4	-	5
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	33	26	7	-	33	-	2	31	1	32
6 Гадаад валютын арилжаа	159	152	7	44	152	7	3	156	9	150
7 Итгэлцлийн үйлчилгээ	40	34	6	-	39	1	3	37	3	37
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	8	2	-	9	1	2	8	2	8
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	37	33	4	-	36	1	4	33	5	32
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.8% буюу 465 ББСБ, салбаруудын 67.3% буюу 187 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.2% буюу 77 ББСБ, салбаруудын 32.7% буюу 91 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 1 ББСБ-уудын тархалт



2020 оны II улирлын байдлаар 73 ББСБ-ын 278 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 58.2 хувийг 11 ББСБ-ын 162 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	77	91		168
Архангай аймаг	1	2	3	1.8%
Баян-Өлгий аймаг	3	1	4	2.4%
Баянхонгор аймаг	4	5	9	5.4%
Булган аймаг	2	-	2	1.2%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.4%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.7%
Дорноговь аймаг	2	6	8	4.8%
Дорнод аймаг	5	7	12	7.1%
Дундговь аймаг	1	2	3	1.8%
Завхан аймаг	2	2	4	2.4%
Орхон аймаг	7	13	20	11.9%
Өвөрхангай аймаг	7	5	12	7.1%
Өмнөговь аймаг	1	10	11	6.5%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.8%
Сэлэнгэ аймаг	6	6	12	7.1%

Төв аймаг	12	2	14	8.3%
Увс аймаг	2	4	6	3.6%
Ховд аймаг	1	3	4	2.4%
Хөвсгөл аймаг	3	4	7	4.2%
Хэнтий аймаг	3	3	6	3.6%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	465	187		652
Сүхбаатар дүүрэг	164	30	194	29.8%
Чингэлтэй дүүрэг	141	26	167	86.1%
Баянгол дүүрэг	71	31	102	61.1%
Баянзүрх дүүрэг	50	46	96	94.1%
Хан-Уул дүүрэг	31	20	51	53.1%
Сонгинохайрхан дүүрэг	7	28	35	68.6%
Багануур дүүрэг	1	4	5	14.3%
Налайх дүүрэг	0	2	2	40.0%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2020 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.5 хувиар буюу 329.0 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 64.0 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2019.II	Нийт дүнд эзлэх хувь	2020.II	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
	дүн		дүн		дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,477,935.1	96.4%	1,791,441.5	96.2%	313,506.4	21.2%
Мөнгөн хөрөнгө	318,846.7	20.8%	395,258.5	21.2%	76,411.8	24.0%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	2,427.3	0.2%	10,263.3	0.6%	7,836.0	322.8%
Зээл (цэврээр)	1,024,509.6	66.8%	1,218,524.8	65.4%	194,015.2	18.9%
Нийт зээл	1,096,712.7	71.5%	1,307,300.6	70.2%	210,587.9	19.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	72,203.1	4.7%	88,775.8	4.8%	16,572.7	23.0%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	4,629.3	0.3%	2,904.0	0.2%	-1,725.3	-37.3%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	10,295.9	0.7%	12,872.6	0.7%	2,576.7	25.0%
Бусад хөрөнгө	117,226.4	7.6%	151,618.3	8.1%	34,391.9	29.3%
Эргэлтийн бус хөрөнгө	55,179.4	3.6%	70,713.4	3.8%	15,534.0	28.2%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	68,126.9	4.4%	87,703.7	4.7%	19,576.8	28.7%
(Хуримтлагдсан элэгдэл)	12,947.5	0.8%	16,990.4	0.9%	4,042.9	31.2%
Нийт хөрөнгийн дүн	1,533,114.5	100.00%	1,862,154.9	100.00%	329,040.4	21.5%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2016 оны мөн үед 676.5 тэрбум төгрөг байсан бол 2020 оны II улирлын байдлаар 2.8 дахин өсөж 1.9 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.2 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 72.7% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 162 ББСБ, 27.3% нь 2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 380 ББСБ-ын хөрөнгө байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,022.8	60	54.9%	11.1%	5.5	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	331.3	102	17.8%	18.8%	5.8	2	3.8	1	-	-
1.9-2.5 тэрбум	196.3	92	10.5%	17.0%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	240.7	149	12.9%	27.5%	-	-	3.1	2	1.7	1
0.6-1.4 тэрбум	47.9	44	2.6%	8.1%	4.3	5	7.7	8	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	23.2	95	1.2%	17.5%	2.1	5	12.3	53	9.1	39
НИЙТ	1,862.2	542	100.0%	100.0%	17.6	13	26.9	64	12.1	45

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн 42.9% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 33.8% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 23.3% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	395.3	359.7	35.5	13.8	385.9	9.4	16.5	378.8	35.8
Бэлэн мөнгө	169.6	168.0	1.7	12.5	163.1	6.5	0.3	169.4	4.8
Харилцах	133.5	115.6	17.9	1.2	130.8	2.8	13.4	120.2	23.0
Хадгаламж	92.1	76.2	15.9	0.1	92.0	0.1	2.8	89.3	8.1

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 46.7%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 4.7%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 90.7% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын харилцах 54.6% буюу 10.4 тэрбум төгрөгөөр өсөж 29.4 тэрбум төгрөгт, валютын хадгаламж 78.2% буюу 22.1 тэрбум төгрөгөөр өсөж 50.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

2020 оны II улирлын байдлаар 17 ББСБ 10.3 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэн байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 28.5% буюу 2.9 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 71.5% буюу 7.3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 29.8% буюу 3.1 тэрбум төгрөг нь хувьцаа, 70.2% буюу 7.2 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	10,263.3	8,985.3	1,278.1	1.0	9,607.0	656.4	8,478.6	1,784.8	7,200.5
Хувьцаа	3,057.8	1,779.8	1,278.1	1.0	2,401.5	656.4	1,278.1	1,779.8	-
Бусад	7,205.5	7,205.5	-	-	7,205.5	-	7,200.5	5.0	7,200.5
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	7,334.4	7,245.4	89.0	-	7,333.4	1.0	7,289.5	44.9	7,200.5
Арилжааны үнэт цаас	2,929.0	1,739.9	1,189.1	1.0	2,273.6	655.4	1,189.1	1,739.9	-

Факторингийн тооцооны авлага

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2019.II		2020.II		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
Хэвийн	4,656.2	100.0%	2,924.8	100.0%	(1,651.2)	-36.6%
Хугацаа хэтэрсэн	85.0	1.8%	39.6	1.4%	(45.4)	-53.4%
Чанаргүй	61.4	1.3%	26.6	0.9%	(34.8)	-56.7%
Хэвийн бус	32.4	0.7%	6.3	0.2%	(26.0)	-80.4%
Эргэлзээтэй	29.1	0.6%	6.1	0.2%	(23.0)	-79.1%
Муу	-	-	14.2	0.5%	14.2	-
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	26.9	0.6%	20.8	0.7%	(6.1)	-22.6%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо нэмэгдсэн хэдий ч 2020 оны II улирлын байдлаар Улаанбаатар хотод байршилтай, уламжлалт санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 3 ББСБ 66.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 20.8 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2.9 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 34 ББСБ-уудын 31 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 2.2 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар өсөж 12.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	12,340.6	10,412.9	1,927.7	12,181.6	159.0	695.9	11,644.7	2,808.6	9,532.1
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	12,505.5	10,053.5	2,452.0	12,353.6	151.9	1,343.7	11,161.8	2,984.7	9,520.8
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	3,265.7	2,604.3	661.4	3,265.7	-	647.8	2,617.8	1,062.7	2,203.0
Өмчлөх бусад хөрөнгө	3,100.8	2,963.7	137.1	3,093.7	7.1	-	3,100.8	886.6	2,214.2

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 19.2% буюу 210.6 тэрбум төгрөгөөр өсөж 2020 оны II улирлын байдлаар 1,307.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 88.8 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,218.5 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,218.5	1,057.7	160.8	1,190.1	28.4	121.8	1,096.7	199.8	1,018.7
Нийт зээл	1,307.3	1,141.4	165.9	1,273.7	33.6	126.1	1,181.2	211.9	1,095.4
ЗЖДХ /иргэн/	2.9%	2.9%	3.1%	2.9%	3.0%	3.4%	3.0%	3.0%	3.0%
ЗЖДХ /ААН/	2.3%	2.3%	1.4%	2.3%	2.3%	2.9%	2.3%	2.7%	2.3%
Хэвийн	1,131.1	978.0	153.0	1,104.2	26.9	118.3	1,012.8	187.4	943.7
Хугацаа хэтэрсэн	62.3	55.5	6.8	61.4	0.8	2.9	59.4	10.0	52.3
Чанаргүй:	113.9	107.9	6.0	108.1	5.9	5.0	109.0	14.5	99.5
-Хэвийн бус	24.7	23.2	1.5	24.2	0.4	1.0	23.6	3.4	21.3
-Эргэлзээтэй	24.2	21.7	2.5	23.5	0.7	1.9	22.3	1.9	22.3
-Муу	65.1	63.1	2.0	60.3	4.7	2.1	63.0	9.2	55.9
(Зээлийн эрсдэлийн сан)	88.8	83.7	5.0	83.5	5.2	4.3	84.5	12.0	76.7
Нийт зээл (төгрөгийн)	1,275.9	1,111.7	164.3	1,242.6	33.3	114.3	1,161.6	195.7	1,080.2
Нийт зээл (валютын)	31.4	29.8	1.6	31.0	0.4	11.8	19.6	16.2	15.2
Зээлдэгчдийн тоо	445,984	152,677	293,307	435,171	10,813	207,051	238,933	31,320	414,664

Оны эхэнд 1.2 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 778.5 тэрбум төгрөгийн зээлийг 2.9 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 717.5 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2020 оны II улирлын байдлаар 1.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 86.5 хувийг буюу 1,131.1 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 4.8 хувийг буюу 62.3 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 8.7 хувийг буюу 113.9 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар



Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өссөн бол хэвийн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7, 0.2 пунктээр тус тус буурсан байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 176.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.4%-д буюу 88.8 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт олгосон зээлийн 64.7% буюу 503.9 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 12.0% буюу 93.2 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 66.5% буюу 476.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 13.4% буюу 96.4 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Хэрэглээ	503.9	64.7%	476.6	66.4%	657.0	50.3%
Бөөний болон жижиглэн худалдаа	93.2	12.0%	96.4	13.4%	207.3	15.9%
Барилга	57.9	7.4%	44.9	6.3%	145.4	11.1%
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	26.5	3.4%	14.8	2.1%	71.6	5.5%
Уул уурхай, олборлолт	16.4	2.1%	12.1	1.7%	46.2	3.5%
Машин мотоциклийн засвар үйлчилгээ	14.9	1.9%	7.8	1.1%	31.8	2.4%
Боловсруулах үйлдвэрлэл	13.9	1.8%	16.7	2.3%	26.7	2.0%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9.5	1.2%	10.3	1.4%	26.0	2.0%
Бусад	42.3	5.4%	38.0	5.3%	95.2	7.3%
<i>Иргэн</i>	704.4	90.5%	656.1	91.4%	1,122.9	85.9%
<i>Хуулийн этгээд</i>	74.1	9.5%	61.4	8.6%	184.4	14.1%
Нийт дүн	778.5	100.0%	717.5	100.0%	1,307.3	100.0%

Олгосон зээлийн 90.5% буюу 704.4 тэрбум төгрөгийн зээлийг иргэдэд, 9.5% буюу 74.1 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.4% буюу 656.1 тэрбум төгрөг нь иргэдээс, 8.6% нь буюу 61.4 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Бусад хөрөнгө

2020 оны II улирлын байдлаарх 151.6 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 53.4% буюу 81.0 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 25.2% буюу 38.2 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 21.4% буюу 32.4 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 18 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	151,618.3	138,000.8	16,117.5	455.0	146,956.9	4,661.4	15,609.5	136,008.8	29,500.2
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	81,039.4	74,542.6	6,496.8	-	79,828.5	1,210.9	5,193.7	75,845.7	15,118.7
-Үнэт цаасны	490.8	490.8	-	-	490.8	-	-	490.8	-
-Зээлийн	78,973.3	72,817.5	6,155.8	-	77,790.2	1,183.1	5,054.9	73,918.4	15,102.2
-Факторингийн	-	-	-	-	-	-	-	-	-
-Бусад	40.5	40.5	-	-	40.5	-	-	40.5	-
Авлага /цэврээр/	1,534.8	1,193.9	340.9	-	1,507.0	27.8	138.7	1,396.1	16.5
Нийт авлага	38,178.9	35,617.4	5,061.5	3.6	35,281.4	2,897.5	5,665.4	32,513.5	7,067.8
Хэвийн	40,014.4	36,669.7	5,844.7	3.6	37,099.3	2,915.2	5,871.6	34,142.9	7,710.0
Хугацаа хэтэрсэн	37,366.5	34,840.9	5,025.6	0.1	34,486.7	2,879.8	5,726.7	31,639.8	6,928.4
Чанаргүй:	564.0	523.5	40.6	3.5	547.7	16.3	-	564.0	56.2
-Хэвийн бус	2,083.8	1,305.3	778.5	-	2,064.8	19.1	144.8	1,939.0	725.4
-Эргэлзээтэй	96.9	96.9	-	-	95.3	1.6	-	96.9	1.5
-Муу	496.1	496.1	-	-	494.6	1.5	-	496.1	292.4
Нийт авлага (валютын)	1,490.8	712.3	778.5	-	1,474.9	15.9	144.8	1,346.0	431.6
Нийт авлага (төгрөгийн)	2,833.8	2,749.2	84.7	-	2,833.8	-	-	2,833.8	350.7
(Авлагын эрсдэлийн сан)	1,835.5	1,052.3	783.2	-	1,817.9	17.6	206.2	1,629.3	642.3
Бусад актив	32,400.0	27,840.8	4,559.2	451.4	31,847.0	552.9	4,750.4	27,649.5	7,313.7

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2020 оны II улирлын байдлаар 70.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 17.0 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна.

Хүснэгт 19 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	70.7	63.1	7.7	0.4	69.4	1.3	9.1	61.7	10.5
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	87.7	78.7	9.0	0.5	85.8	1.9	9.9	77.8	12.6
Барилга байгууламж	30.5	27.2	3.3	0.0	29.8	0.7	1.2	29.2	2.6
Техник хэрэгсэл	31.2	29.3	1.8	0.1	30.3	0.9	1.1	30.1	2.8
Тавилга эд хогшил	9.7	8.7	1.0	0.2	9.4	0.3	0.5	9.2	0.9
Дуусаагүй барилга	7.8	7.5	0.3	-	7.8	-	4.3	3.5	4.2
Биет бус хөрөнгө	8.5	6.0	2.5	0.2	8.4	0.1	2.7	5.8	2.1
(Хуримтлагдсан элэгдэл)	17.0	15.7	1.3	0.1	16.4	0.6	0.8	16.2	2.0
Барилга байгууламжийн	2.8	2.4	0.5	0.0	2.7	0.1	0.3	2.5	0.1
Техник хэрэгслийн	10.5	9.9	0.6	0.0	10.2	0.4	0.4	10.1	1.6
Тавилга эд хогшлын	3.6	3.4	0.2	0.1	3.5	0.1	0.1	3.6	0.4

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 55.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 20 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2019.II	Нийт дүнд	2020.II	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	эзлэх хувь	дүн	эзлэх хувь	дүн	хувь
Өр төлбөр	377,956.6	24.7%	524,478.5	28.2%	146,521.9	38.8%
Санхүүгийн эх үүсвэр	84,140.5	5.5%	118,643.5	6.4%	34,503.0	41.0%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	167,315.2	10.9%	212,337.5	11.4%	45,022.3	26.9%
Бусад эх үүсвэр	15,044.5	1.0%	33,230.5	1.8%	18,186.0	120.9%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	33,805.6	2.2%	52,320.2	2.8%	18,514.6	54.8%
Төслийн зээлийн санхүүжилт	17,809.6	1.2%	23,432.1	1.3%	5,622.5	31.6%
Бусад өр төлбөр	59,841.2	3.9%	84,514.6	4.5%	24,673.4	41.2%
Эздийн өмч	1,155,158.0	75.3%	1,337,676.4	71.8%	182,518.5	15.8%
Хувьцаат капитал	892,235.6	58.2%	977,347.5	52.5%	85,111.9	9.5%
Бусад өмч	31,253.9	2.0%	32,867.8	1.8%	1,613.9	5.2%
Сангууд	776.5	0.1%	721.9	0.0%	(54.7)	-7.0%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	230,055.3	15.0%	325,902.6	17.5%	95,847.3	41.7%
Хоёрдогч өглөг	836.6	0.1%	836.6	0.0%	-	0.0%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	1,533,114.5	100.0%	1,862,154.9	100.0%	329,040.4	21.5%


Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2016 оны мөн үед 388.8 тэрбум төгрөг байсан бол 2020 оны II улирлын байдлаар 2.5 дахин өсөж 977.3 тэрбум төгрөгт, өр төлбөрийн хувьд 3.1 дахин өсөж 524.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 4 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Санхүүгийн эх үүсвэр

Зураг 5 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Хүснэгт 21 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	118.6	80.1	38.5	117.7	1.0	44.1	74.6	35.2
-Төгрөгөөр	87.5	64.9	22.6	86.5	1.0	24.8	62.7	23.8
-Валютаар	31.2	15.3	15.9	31.2	-	19.3	11.8	11.4
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	40	34	6	39	1	3	37	3
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	33	29	4	32	1	3	30	3
Нийт итгэмжлэгчдийн тоо	2,701	2,408	293	2,700	1	250	2,451	250

Хамгийн өндөр дүнгээр 24.8 тэрбум төгрөгийг 126 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон итгэмжлэгчээс 1,179 хувь хүн, хуулийн этгээдээс 826.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2020 оны II улирлын байдлаар 90 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 212.3 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 22 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
	212.3		197.2	15.2	211.9	0.5	18.3	194.0	78.8	133.5
Хугацаагаар:										
Богино хугацааг зээл /1 жил хүртэлх/	97.2	45.8%	87.5	9.7	97.0	0.3	3.8	93.4	33.8	63.4
Урт хугацааг зээл /1 жилээс дээш/	115.1	54.2%	109.6	5.5	114.9	0.2	14.5	100.6	44.9	70.2
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	121.2	57.1%	106.1	15.2	120.7	0.5	18.3	102.9	21.0	100.2
Валютаар	91.1	42.9%	91.1	-	91.1	-	-	91.1	57.8	33.3
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	124.3	58.5%	109.1	15.2	123.8	0.5	18.3	106.0	21.5	102.8
Зээл /төгрөгөөр/	121.2	57.1%	106.1	15.2	120.7	0.5	18.3	102.9	21.0	100.2
Зээл /валютаар/	3.1	1.4%	3.1	-	3.1	-	-	3.1	0.5	2.6
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	88.0	41.5%	88.0	-	88.0	-	-	88.0	57.3	30.8

Бусад эх үүсвэр


Хүснэгт 23 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Нийт	33,230.5	100.0%	5,008.9	28,221.6	33,230.5	-	921.4	32,309.1	1,152.7	32,077.8
Зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэр	66.95	0.2%	66.9	-	66.9	-	-	66.9	-	66.9

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	7,784.81	23.4%	2,385.6	5,399.2	7,784.8	-	921.4	6,863.4	1,152.7	6,632.1
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	199.38	0.6%	-	199.4	199.4	-	-	199.4	-	199.4
Факторингийн үйлчилгээний өглөг	25,179.37	75.8%	2,556.3	22,623.0	25,179.4	-	-	25,179.4	-	25,179.4

2020 оны II улирлын байдлаар 1 ББСБ 66.9 сая төгрөгийн зээлийн батлан даалтад байршуулсан эх үүсвэрийн үлдэгдэлтэй, 7 ББСБ 7.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 1 ББСБ 199.4 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй, 2 ББСБ 25.2 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарчээ.

Зураг 6 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/



Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг болон факторингийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс харгалзан 2.5, 3.1 дахин өссөн бол төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 3.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг


2020 оны II улирлын байдлаар 30 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 800 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 52.3 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 24 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Төгрөгөөр	46.3	27.1	19.2	46.2	0.1	10.9	35.3	2.8
Валютаар	6.0	0.8	5.3	6.0	-	1.7	4.4	-

Өрийн бичгийн үлдэгдэл 2016 оны мөн үеэс 38.9 дахин өсөж 52.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 2.9% байсан бол 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 8.6 пунктээр өсөж 11.6%-д хүрсэн байна.

Зураг 7 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Төслийн зээлийн санхүүжилт

Төсөл хөтөлбөрөөс 40 ББСБ 23.4 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Нээлттэй хувьцаат компанийн хувьд төслийн зээл санхүүжилтийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 25 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн 23,432.1	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт 19,592.1	Финтек 3,840.0	УБ 21,019.8	ХОН 2,412.2	ГХО 9,005.5	Дотоод 19,592.1
Хугацаагаар								
Богино хугацаат /1 жил хүртэлх/	6,637.4	28.3%	3,390.4	3,247.0	6,381.6	255.8	941.0	6,637.4
Урт хугацаат /1 жилээс дээш/	16,794.7	71.7%	16,201.7	593.0	14,638.2	2,156.4	8,064.5	16,794.7
Төрлөөр								
Засгийн газрын	475.0	2.0%	475.0	-	395.0	80.0	-	475.0
Гадаадын	11,238.5	48.0%	8,692.8	2,545.7	11,238.5	-	8,004.5	11,238.5
Дотоодын	6,117.8	26.1%	5,647.8	470.0	5,942.0	175.8	1,001.0	6,117.8
Бусад	5,600.8	23.9%	4,776.5	824.3	3,444.4	2,156.4	-	5,600.8
Валютын төрлөөр								
Төгрөгөөр	19,797.5	84.5%	16,169.2	3,628.3	17,385.2	2,412.2	5,582.6	19,797.5
Валютаар	3,634.6	15.5%	3,422.9	211.7	3,634.6	-	3,422.9	3,634.6

2020 оны эхний хагас жилийн байдлаар 33 ББСБ 5.9 тэрбум төгрөгийн Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Бусад өр төлбөр

2020 оны II улирлын байдлаар 493 ББСБ 84.5 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 31.4% буюу 26.2 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 68.9% буюу 58.3 тэрбум төгрөг нь бусад пассивын үлдэгдэл байна.

Хүснэгт 26 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн 84,514.6	Уламжлалт 67,487.2	Финтек 17,027.5	ЗГВА 112.2	УБ 83,344.8	ХОН 1,169.8	ХК 15,017.4	ХХК 69,497.2	ГХО 22,739.4	Дотоод 61,775.2
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	26,249.4	22,619.1	3,630.3	-	26,245.0	4.4	7,221.3	19,028.2	10,470.0	15,779.4
Ангиллаар										
Зээлийн	20,178.0	18,622.1	1,555.8	-	20,177.2	0.8	5,184.7	14,993.2	8,574.0	11,603.9
Үнэт цаасны	726.3	335.2	391.1	-	726.3	-	226.6	499.7	-	726.3
Бусад	5,345.2	3,661.8	1,683.4	-	5,341.6	3.6	1,809.9	3,535.2	1,896.0	3,449.2
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	24,727.3	21,479.1	3,248.2	-	24,722.9	4.4	6,562.0	18,165.3	9,779.5	14,947.8
Валютаар	1,522.1	1,140.0	382.1	-	1,522.1	-	659.2	862.9	690.5	831.6
Бусад пассив	58,265.2	44,868.1	13,397.2	112.2	57,099.8	1,165.4	7,796.1	50,469.0	12,269.3	45,995.9

Хувь нийлүүлсэн хөрөнгө


2020 оны II улирлын байдлаар 542 ББСБ-ын 977.3 тэрбум төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 749.7 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 476.5 сая төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.5% буюу 85.1 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт пассивын 52.5 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 27 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
	977,347.5	921,293.7	58,553.8	13,589.9	943,134.3	34,213.2	28,804.8	948,542.6	94,899.8	882,447.7
Энгийн хувьцаа	977,074.2	920,754.4	58,819.9	13,589.9	942,903.3	34,170.9	29,074.5	947,999.7	94,782.4	882,291.9
Давуу эрхтэй хувьцаа	749.7	749.7	-	-	707.4	42.3	-	749.7	121.0	628.7
Халаасны хувьцаа	476.5	210.4	266.1	-	476.5	-	269.7	206.8	3.6	472.9

Хувьцаат капиталын хэмжээ 2016 оны мөн үеэс 2.5 дахин өсөж 977.3 тэрбум төгрөгт, давуу эрхийн хувьцаа 50.0 дахин өсөж 749.7 сая төгрөгт халаасны хувьцаа 2.3 дахин өсөж 476.5 сая төгрөгт хүрсэн байна.

Зураг 8 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 188 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 61.6% буюу 601.6 тэрбум төгрөг байна.

Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 354 ББСБ-ын 375.8 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 38.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 28 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	185.2	22	18.9%	4.1%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	281.8	99	28.8%	18.3%	2.5	1	2.7	1	-	-
1.9-2.5 тэрбум	134.6	67	13.8%	12.4%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	328.9	227	33.6%	41.9%	-	-	1.4	1	1.4	1
0.6-1.4 тэрбум	25.7	28	2.6%	5.2%	2.0	3	7.0	8	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	21.3	99	2.2%	18.3%	3.4	8	9.5	54	8.5	39
НИЙТ	977.3	542	100.0%	100.0%	13.5	13	20.7	64	13.6	44

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар 32.9 тэрбум төгрөгт, сангууд 7.0 хувиар буурч 721.9 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 29 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Бусад өмч	32,867.8	26,005.2	6,862.7	275.4	32,455.6	412.3	22,240.4	10,627.4	16,289.0	16,578.9
Нэмж төлөгдсөн капитал	28,302.1	21,496.7	6,805.3	257.7	28,154.2	147.9	22,183.1	6,119.0	16,278.3	12,023.8
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,312.7	2,312.7	-	-	2,182.6	130.2	-	2,312.7	5.7	2,307.0
Хандивын капитал	2,253.1	2,195.7	57.3	17.8	2,118.8	134.2	57.3	2,195.7	5.0	2,248.1
Сангууд	721.9	721.9	-	-	90.8	631.0	-	721.9	2.5	719.4
Ноогийн сан	452.7	452.7	-	-	6.4	446.3	-	452.7	-	452.7
Нийгмийн хөгжлийн сан	269.2	269.2	-	-	84.4	184.8	-	269.2	2.5	266.7

Хуримтлагдсан ашиг/алдагдал

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 41.7% буюу 95.8 тэрбум төгрөгөөр өсөж 325.9 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 30 Хуримтлагдсан ашиг/алдагдал /мянган төгрөгөөр/

	ХУРИМТЛАГДСАН АШИГ/АЛДАГДАЛ		
	/2020-II/	-Тухайн үеийн	/2019-IV/
2019.II	230,055,338.15	64,253,028.26	165,802,309.89
2020.II	325,902,648.24	76,612,981.53	249,289,666.71
	ББСБ тоо	Дүн	Дүн
Уламжлалт	531	295,116,810.5	67,465,285.0
Финтек	11	30,785,831.4	9,147,690.2
ЗГВА	44	663,958.0	-120,351.1
УБ	465	321,735,359.5	74,515,943.8
ХОН	77	4,167,288.8	2,097,037.8
ХК	4	26,924,897.3	8,878,151.7
ХХК	538	298,977,751.0	67,734,829.8
ГХО	31	24,331,538.6	8,409,570.6
Дотоод	511	301,571,109.6	68,203,410.9

Хоёрдогч өглөг


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татсан ББСБ-уудын тоо болон хэмжээнд өөрчлөлт ороогүй ба 2020 оны

II улирлын байдлаар 5 ББСБ 836.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2020 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 200.2 тэрбум төгрөгийн орлого олж, 123.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж 76.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 9 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 26.5% буюу 41.9 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 31.5% буюу 29.6 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 19.2% буюу 12.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 31 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2019.ИИ	2020.ИИ	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	132,902.8	163,652.7	81.7%	30,750.0	23.1%
Хүүгийн бус орлого	22,351.4	32,497.5	16.2%	10,146.0	45.4%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	17,290.0	23,465.3	11.7%	6,175.2	35.7%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	0.8	4.1	0.0%	3.3	434.1%
- Мөнгөн гуйвуулгын орлого	444.9	628.8	0.3%	183.9	41.3%
- Картын үйлчилгээний орлого	-	1,061.7	0.5%	1,061.7	-
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	118.7	138.9	0.1%	20.2	17.0%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	13,184.1	16,803.2	8.4%	3,619.1	27.5%
- Бусад	3,541.5	4,828.5	2.4%	1,287.0	36.3%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	3,012.6	4,044.0	2.0%	1,031.4	34.2%
НИЙТ ОРЛОГО	158,266.8	200,194.2	100.0%	41,927.4	26.5%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	15,122.6	22,291.1	18.0%	7,168.5	47.4%
Хүүгийн бус зардал	53,299.9	70,567.2	57.1%	17,267.3	32.4%
Болзошгүй эрсдэлийн зардал	16,177.5	20,984.2	17.0%	4,806.7	29.7%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,473.3	1,679.4	1.4%	206.1	14.0%
Орлогын албан татварын зардал	7,940.4	8,060.8	6.5%	120.4	1.5%
Ердийн бус зардал	-	11.9	-	11.9	-
НИЙТ ЗАРЛАГА	94,013.7	123,594.7	100.0%	29,580.9	31.5%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	64,253.0	76,599.5	100.0%	12,346.5	19.2%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус орлого 45.4% буюу 10.1 тэрбум төгрөгөөр өсжээ. Энэхүү өсөлтийн 60.9 хувийг санхүүгийн үйлчилгээний орлогын өсөлт бүрдүүлж байна. Финтек буюу санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ууд зээлдэгчдийн хэрэглээнд зориулсан бичил зээл олгохдоо ихэвчлэн хүү тогтоохгүйгээр, шимтгэл авч байгаа нь энэхүү орлогыг нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна. Мөн хүүгийн бус орлогын өсөлтөд бага нөлөө үзүүлж байгаа хэдий ч өмнөх оны мөн үеэс итгэлцлийн үйлчилгээний орлого 5.3 дахин буюу 3.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал байна. Хүүгийн зардал 47.4% буюу 7.2 тэрбум төгрөгөөр өссөн ба энэхүү өсөлтийн 78.8

хувийг бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал болон өрийн бичгийн хүүгийн зардлын өсөлт бүрдүүлж байна.

Харин нийт зардлын өсөлтийн 58.4 хувийг хүүгийн бус зардлын өсөлт бүрдүүлж байна. Хүүгийн бус зардал нь өмнөх оны мөн үеэс 32.4% буюу 17.3 тэрбум төгрөгөөр өсөж 70.6 тэрбум төгрөгт хүрчээ. Энэхүү өсөлтийн 32.5 хувийг ажилтнуудын цалингийн зардал, 39.0 хувийг бусад зардлын өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 32 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Хүүгийн орлого	163,652.7	147,922.4	15,730.3	4.8	159,689.0	3,963.7	15,311.2	148,341.6	99,700.9	63,951.8
Хүүгийн бус орлого	32,497.5	17,036.2	15,461.3	552.2	32,296.6	200.9	13,097.5	19,399.9	23,415.7	9,081.8
- Санхүүгийн үйлчилгээний орлого	23,465.3	8,748.3	14,717.0	10.1	23,269.2	196.1	10,735.1	12,730.2	17,361.3	6,103.9
Итгэлцлийн үйлчилгээний орлого	4.1	-	4.1	-	4.1	-	-	4.1	4.1	-
Мөнгөн гуйвуулгын орлого	628.8	628.8	-	9.6	628.8	-	-	628.8	66.5	562.3
Картын үйлчилгээний орлого	1,061.7	1,061.7	-	-	1,061.7	-	-	1,061.7	-	1,061.7
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	138.9	112.3	26.7	-	133.9	5.0	26.7	112.3	133.8	5.1
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	16,803.2	2,344.9	14,458.3	-	16,634.0	169.2	10,668.7	6,134.5	14,443.5	2,359.8
Бусад	4,828.5	4,600.6	227.9	0.6	4,806.7	21.8	39.7	4,788.8	2,713.5	2,115.1
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4,044.0	3,789.9	254.1	4.9	3,868.2	175.8	222.1	3,821.9	2,920.1	1,123.9
НИЙТ ОРЛОГО	200,194.2	168,748.6	31,445.6	561.9	195,853.8	4,340.4	28,630.8	171,563.4	126,036.7	74,157.5
ЗАРДАЛ										
Хүүгийн зардал	22,291.1	17,532.8	4,758.3	-	22,190.3	100.8	3,663.2	18,627.9	18,773.3	3,517.8
Хүүгийн бус зардал	70,567.2	56,031.9	14,535.3	675.8	68,934.2	1,633.0	12,642.3	57,924.9	43,993.6	26,573.6
Болзошгүй эрсдэлийн зардал	20,984.2	19,210.6	1,773.7	-	20,700.1	284.1	2,179.5	18,804.8	10,808.3	10,175.9
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,679.4	1,393.6	285.8	2.1	1,617.0	62.4	264.6	1,414.8	811.5	867.9
Орлогын албан татварын зардал	8,060.8	7,115.9	944.9	5.0	7,897.8	163.0	1,003.1	7,057.6	5,249.0	2,811.8
Ердийн бус зардал	11.9	11.9	-	-	10.7	1.2	-	11.9	0.3	11.6
НИЙТ ЗАРЛАГА	123,594.7	101,296.7	22,298.0	682.9	121,350.1	2,244.6	19,752.7	103,842.0	79,636.0	43,958.6
АШИГ										
ЦЭВЭР ОРЛОГО	76,599.5	67,451.9	9,147.7	(121.0)	74,503.7	2,095.8	8,878.2	67,721.4	46,400.7	30,198.9

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын 4.8 сая төгрөгийн хүүгийн орлогыг 4 ББСБ-ын банкн дахь харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлж байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2020 оны II улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 542 ББСБ-ын 80.4% буюу 436 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 19.6% нь буюу 106 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 90 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 11 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 5 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 33 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /40 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /458 ББСБ/		ЗГВА /44 ББСБ/		Нийт /542 ББСБ/	
		√	X	√	X	√	X	√	X
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	40	-	448	10	42	2	530	12
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	40	-	446	12	42	2	528	14
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	40	-	454	4	44	-	538	4
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	38	2	412	46	37	7	487	55
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дугуу)	40	-	458	-	-	-	542	-
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	39	1	451	7	-	-	534	8
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	40	-	458	-	-	-	542	-
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	40	-	457	1	-	-	541	1
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	40	-	456	2	XXX	-	540	2
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40	-	458	-	-	-	542	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40	-	458	-	-	-	542	-
12.	Монголын хөрөнгийн биржийн "Г", "П" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	40	-	458	-	-	-	542	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40	-	458	-	-	-	542	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	39	1	457	1	-	-	540	2
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40	-	448	10	38	6	526	16
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40	-	-	XXX	XXX	-	-	542
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	40	-	457	1	-	-	541	1
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	39	1	444	14	43	1	526	16

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 55 ББСБ хангаагүй, хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 25 ББСБ дутуу байгуулсан, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа болон гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тус бүр 16 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Дүгнэлт

2020 оны эхний хагас жилийн тайлан мэдээг ирүүлбэл зохих 542 ББСБ-аас 529 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 13 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2020 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 8,404 хувьцаа эзэмшигчдийн 542 ББСБ, 278 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,372 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,8 сая харилцагч, 446.0 мянган зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Эдгээр ББСБ-уудын 77 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 31 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ, Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ үзүүлж байгаа 11 ББСБ байна.

Тайлант улиралд банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар буюу 329.1 тэрбум төгрөгөөр өсөж, 1.9 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт хөрөнгийн 5.4%-тай тэнцэж байна. Активын өсөлтийн 64.0 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 25.9 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Нийт зээл өмнөх оны мөн үеэс 27.6%, оны эхнээс 6.0%-аар өсөж 1.3 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 7.6%-тай тэнцэж байна. Нийт зээлийн 86.5 хувийг хэвийн зээл, 4.8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.7 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.9 пунктээр өссөн бол хэвийн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.7 болон 0.2 пунктээр тус тус буурсан байна. Харин зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.9 хувьтай байгаа бөгөөд хүүгийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан хэдий ч банкны салбартай харьцуулахад 1.5 пунктээр өндөр байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 9.5%, оны эхнээс 5.4%-аар өсөж 977.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин өндөр байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа явуулдагтай холбоотой.

2020 оны II улирлын байдлаар ББСБ-ууд 200.2 тэрбум төгрөгийн орлого олж, 123.6 тэрбум төгрөгийн зардал гаргаж 76.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Нийт орлогын хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 хувиар буюу 41.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 31.5 хувиар буюу 29.6 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 19.1 хувиар буюу 12.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

542 ББСБ нь санхүүгийн 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байгаагаас 91.9% нь буюу 498 ББСБ нь зээлийн үйл ажиллагаа, 29.3% буюу 159 ББСБ нь гадаад валютын арилжааны үйл ажиллагааг голлон эрхэлж байна.

ББСБ-ын нийт хувьцаа эзэмшигчдийн 87.5% буюу 7,352 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон буюу хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч байгаа бол 12.5% буюу 1,052 нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна.

ББСБ-ын салбарт шинэ дэвшилтэд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтэрч эхэлсэнтэй холбоотойгоор ББСБ-ын харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өсжээ. Тэдгээр нь нийт харилцагчдын 92.0%-ийг, зээлдэгчдийн 65.8%-ийг эзэлж байна.

Нийт ББСБ-ын 80.3% буюу 435 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол 19.7% нь буюу 107 ББСБ зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

Эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, орлого тасалдах, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байгааг харгалзан санхүүгийн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 дугаар тушаалаар “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулснаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын 228.6 тэрбум төгрөгийн зээлийг ангилал буурахаас хамгаалсан байна.

Түр журмын үйлчлэх хугацаанд зээлдэгчдийг богино хугацаандаа зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлтийг хойшлуулж байгаа хэдий ч урт хугацаандаа өрийн дарамтад орох, ирээдүйд төлөх зээлийн төлбөр, хуримтлуулсан хүү илүү өндөр болох эрсдэлтэй юм. Энэ нь ирээдүйд ББСБ-ын салбарын чанаргүй активын хэмжээг огцом өсгөх, эргэлтийн хөрөнгийн хөрвөх чадвар буурч, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Цаашид Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах, Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулах зэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх мөн санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 05 дугаар тогтоолоор баталсан “[Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар](#)”-ын дагуу бэлтгэх, Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулан зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас авч буй Ковид-19-тэй холбоотой зээлийн мэдээллийг сар бүрийн 10-ны дотор Google form-оор ирүүлж байхыг анхаарч ажиллах шаардлагатай байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР